



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1992 оны 08 сарын 13

№ 28

Улаанбаатар
хот

Барилгын Монгол Мурса компани
/УУГ/ байгуулах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. Дэвшилт техник, технологийг ашиглан амины орон сууц, бага хүч чадлын нийгэм соёлын болон ахуй үйлчилгээний барилгын зураг төсөл зохиох, хийц бүтээцийг үйлдвэрлэх, барих үүрэгтэй барилгын "МОНГОЛ-МУРСА" компанийг /УУГ/ 1992 оны 2-р сарын 15-наас зохион байгуулж ажилдуулсугай.

2. "МОНГОЛ-МУРСА" компанийг /УУГ/ дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3. "МОНГОЛ-МУРСА" компанийг үйл ажиллагааг эхлүүлэхэд нь зориулж 1,0 сая төгрөгийг хотын төсвөөс олгохыг хотын санхүүгийн газар /н.Тонгор/-т зөвшөөрсүгэй.

4. Улаанбаатар хотын Барилгын 2-р компанийг иж бүрдүүлэх цехийн захиргаа, ахуйн барилгын нэг давхар, блок агуулахын нэг хэсэг, нэг задгай саравч зэргийг Мурса системийн хийц, эдлэл үйлдвэрлэхэд зориулж "МОНГОЛ-МУРСА" компанид шилжүүлэхийг Барилгын 2-р компани /н.Балдан-Осор/-д даалгасугай.

5. Мурса системийг нэвтрүүлэх талаар "МОНГОЛ-МУРСА" компанитай хамтран ажиллахыг хотын барилгын компани /н.Балдан-Осор/-д үүрэг болгосугай.

6. Маахуур толгойн 12,0 га, Яармагийн 3,0 га талбайд Монгол-Мурса системийг ашиглан амины орон сууцны иж бүрэн хороолол барихыг хот байгуулалт төлөвлөлтийн газар /н.Болд/, Барилга хөрөнгө оруулалтын газар /н.Нэргүй/-т үүрэг болгосугай.

7. Барилга хөрөнгө оруулалтын газрын байрыг хот байгуулалт, төлөвлөлтийн газрын барилгатай холбон өргөтгөл хийж, Монгол-Мурса компанийг захиргаа, зураг төслийн товчоо, үйлчилгээний барилга барихыг зөвшөөрсүгэй.

2.

8. Гадаадын дэвшилт техник, технологийг чөлөөтэй орж ирэх нөхцлийг хангахын тулд Варшавын Политехникийн Их сургуультай хамтарсан жижиг, дунд үйлдвэр байгуулж ажиллах, хэлэлцээр хийхийг "Туул-Импекс" компани /н.Санчин/, Барилга хөрөнгө оруулалтын газар /н.Нэргүй/т зөвшөөрсүгэй.

9. "МОНГОЛ-МУРСА" компаний үйлдвэрлэл үйлчилгээний байрыг бэлтгэх, зарим нэрийн машин механизм, тоног төхөөрөмж, түүхий эд материалыг худалдан авах, хэв хашмал хийлгэхэд шаардлагатай 5,0 сая төгрөгийг жижиг дунд үйлдвэр байгуулахад зориулсан хөрөнгөөс санхүүжүүлэхийг хотын Нийгэм эдийн засгийн бодлогын зөвлөл /н.Ганхуяг/, Барилга, хөрөнгө оруулалтын газар /н.Нэргүй/-т зөвшөөрсүгэй.

10. "МОНГОЛ-МУРСА" компанид шаардлагатай машин, тоног төхөөрөмж олж нийлүүлэхэд дэмжлэг үзүүлж, шатахуунаар хангах арга хэмжээ авахыг Материал хангамжийн хэлтэс /н.Ангжидсүрэн/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХҮҮЛЭН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР
ГАМНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хурлын
гүйцэтгэх захиргааны 1992 онч. 38
тоот тогтоолын хэсгэлт.

БАРИЛГЫН "МОНГОЛ-МУРСА" КОМПАНИ
/УУТ/-ЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэснэл

1. Барилгын "МОНГОЛ-МУРСА" компани /УУТ/ /цаашид компани гэж нэрлэх/ нь дэвшилт технологи ашиглан жижиг орон сууц, нийгэм соёлын барилгын зураг төсөл зохиох, барилгын үндсэн хийц бүтээцийг үйлдвэрлэх, барих ажлыг аж бүрэн гүйцэтгэх барилгын үнэ өртөгийг хямдруулах эрэл хайгуул хийх үүрэгтэй, аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллах, бие даасан тайлан танилцалтай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээх Монгол улсын хуулийн этгээд мөн.

2. Компани нь өөрийн ажиллагааг Монгол улсын аж ахуйн нэгжийн хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн дагуу явуулна.

3. Компани нь аж ахуй санхүү нийгэм эдийн засгийн үйл ажиллагааныхаа үр дүнг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны өмнө шууд тайлагнана.

4. Компани нь улс, хот болон тэдгээрийн байгууллагуудын хүлээсэн үүргийг хариуцахгүй, компанийн хүлээсэн үүргийг улс, хот болон тэдгээрийн байгууллагууд хариуцахгүй.

5. Компани нь мөцөлдээ байгаа эл хөрөнгийг эзэмших, алагдах, захиран зарцуулах эрхээ Монгол улсын хууль тогтоомж болон энэхүү дүрэм нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу хэрэгжүүлнэ.

6. Компани нь өөрийн нэр бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

7. Компани нь Улаанбаатар хотод байрлана.

ХАЯГ: Октябрь дүүрэг үйлдвэрийн баруун бүс

Хоёр. Компаний үйл ажиллагааны чиглэл

8. Компани нь энэхүү дүрмийн нэгдүгээр бүлгийн I дүгээр зүйлээс заасан зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өөрийн үйл ажиллагаанаа дараах чиглэлийг баримтлан ажиллана. Үүний:

а/Барилгын үнэ өртөгийг хямдруулах нөхцлийг бүрдүүлэхийн тулд дэвшилт техник технологийг судалж нэвтрүүлэх.

б/Байгууллага иргэдийн захиалтыг үндэслэн зураг төсөл зохиох, тарахдаа дэвшилт техник технологийг тусган нэвтрүүлэх.

в/Эхний ээлжинд Польшийн "MURSA" системийг барилгад өргөн нэвтрүүлэх, цаашил дэвшилт техник технологийг өргөнөөр авч хэрэглэх үйл ажиллагаа явуулах.

г/Гадаадын байгууллагатай өөрийн үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах.

д/Сонгож авсан технологийн дагуу барилгын хийц бүтээцийн үйлдвэрлэл зохион байгуулах.

е/Шинэ техник технологийг нэвтрүүлэхтэй холбоотой сургалт зохион байгуулах, сонирхогч байгууллага, хувь хэмжүүсийн зураг төсөл техникийн баримт бичиг, машин тоног төхөөрөмжөөр хангах түрээсээр эзэмшүүлэх.

ж/Компаний бие даасан байдал, үр ашигтай ажиллах нэхцлийг хангах зорилгоор худалдаа, үйлчилгээ зохион байгуулах.

з/Өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай импортын болон дотоод материалыг олж гаргээлэх.

и/Бүтээгдэхүүн эзлэх үйлчилгээний чанарыг сайжруулж, зах зээлд амжилттай өрсөлдөх нөхцөл бололцоог хангах.

Турав: Компаний зорх

9.Компани нь энэхүү дүрмийн хоёрдугаар бүлгийн 8 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу дараах эрхийг хүлээнэ. Үүнд:

а/Монгол улсын нутаг дэвсгэр дээр болон хилийн чанадад орших гадаад дотоодын үйлдвэр, аж ахуйн байгууллага, компани, хоршоо нийгэмлэг, хувь хүмүүстэй харьцаж талантэй бүх төрлийн гэрээ хэлцэл байгуулах, харилцан ашигтай байх үндсэн дээр хоршин ажиллах.

б/Өөрийн үйл ажиллагаа, ашиг сонирхолтой холбогдсон асуудлаар шүүх, арбитрийн байгууллагад нэхэмжлэл гаргах, хариуцагчтар оролцох.

в/Монгол улсын нутаг дэвсгэр дээр болон хилийн чанадад өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай туслах үйлдвэр, барилга байгууламж болон хөдлөх хөрөнгийн чанартай зүйлийг түрээсээр ашиглах, ашигдуулах, худалдах ба худалдан авах.

г/Монгол улсын нутаг дэвсгэртэй болон хилийн чанадад өөрийн компанийн сайбар, контор, төлөөлөгчийн газрыг тогтсон журмын

дагуу байнга буюу түр нээн ажиллуулах, татан буулгах.

д/Монгол улсын болон гадаадын банкны үндэсний болон чөлөөт валютын данстай байх, өөрийн валютын харатсэлийг зохих журмын дагуу хуутайгээр хадгалуулах, түүнийг өөрийн мэдлээр зарцуулж ашиглах.

е/Монгол улсын банкны байг урлагатай тохиролцсоны үндсэн дээр үндэсний болон чөлөөт валютын зээл авах, өөр байгууллагад урт богино хугацааны зээл олгох, хувь цамжигчээр оролцох зэрэг валют, санхүү үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өрнүүлэн ажиллах.

ж/Төрөл бүрийн реклам, сурталчилгааны ажил явуулна.

з/Өөрийн үйлдвэ дэл, үйлчилгээ, бүтээгдэхүүний техникийн нөхцөл, стандарт, барааны тэмлэгийг боловсруулан батлуулж мөрдөх.

Дөрөв. Компаний эл хөрөнгө.

10.Компаний эл хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгөнөөс бүрдэх дүрмийн сан мөн компанийн үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгө, эдийн засгийн урамшуулалын сан болон компанийн мэдэлд өгсөн бусад хөрөнгөнөөс бүрдэнэ.

11.Компаний дүрмийн сан 5,0 оян төгрөг болно.

Тав.Компаний бүтэц, удирдлага

12.Компани нь захиргаа үйлдвэрлэлийн нэгжээс бүрдэнэ.

13.Компани нь өөрийн болон салбар нэгжийн бүтцийг өөрөө тогтоох ба түүнийг ажлын шаардлагаар боловсронгуй болгон өөрчилж болно.

14.Компанийг ерөнхий захирал удирдана.

15.Ерөнхий захирлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа гэрээний үндсэн дээр томилох ба ерөнхий захирал эхлээ түүний өмнө хариуцаж тайлагнаж компаний үйл ажиллагаа, үр дүнт бүрэн хариуцна.

16.Ерөнхий захирал нэр дурьдсан арх эдэлж, үүрэг хүлээнэ.

Үүнд: а/Компаний нэрийн өмнөөс гадаад потоодын байгууллага иргэнтэй итгэмжлэхгүйгээр шууд харилцаж, төрөл бүрийн гэрээ байгуулж, хэлцэл хийх,

б/Компаний эл хөрөнгийг Монгол улсын Үндсэн хууль тогтоомжинд заасны дагуу захиран хариуцна

в/Компаний ажилтан, албан хаагчийг ажилл авах, ажлаас хялах, шагнаж урамшуулах, сахилгын арга хэмжээ авах

г/Тогтоосон журмын дагуу банкинд харилгах болон бусад данс нээлгэх.

д/Эрх хэмжээнийхээ дагуу тухал, заавар гаргах.

е/Компаний ажилтнуудын ажил үүргийн хуваарь, эрх хэмжээг хуваариалан тогтоох.

Зургаа. Тайлан гаргах, ашиг алдагдлаа хуваарилах

17.Компаний санхүүгийн жилийг жил бүрийн I дугаар сарын I-нээс 12 дугаар сарын 31-нийг дуустал тогтооно.

18.Компаний тайлан тэнцлийг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу гаргаж батлана.

19.Компаний орлогыг Монгол улсын хууль тогтоомж, энэхүү дүрмийн дагуу хуваарилана.

20.Компаний санхүү аж ахуйн үйл ажиллагааг жинан шалгах ажлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Долоо. Компанийг этан буулгах, зусийн тооцоо хийх

1.Компаний үйл ажиллагааг Монгол улсын аж ахуйн нэгжийн хуулийн 5 дугаар зүйлд заасан үндэслэлийн дагуу Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр зогсооно.

2.Компаний зусийн тооцоог хууль, тогтоомжид заасан журмаар тусгай комисс томилон тооллого үнэлгээ хийж, нийтэд зарлан мэдэгдэж, тайлан буулгана.